



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2025 оны 01 сарын 10 өдөр

Дугаар А/06

Улаанбаатар хот

┌ Тушаалд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай ┐

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, 24 дүгээр зүйлийн 24.6.6, 24.6.7 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Эрүүл мэндийн сайдын 2022 оны “Төрөөс эмийн зардлыг нь хариуцан амбулаториор эмчлэх өвчний жагсаалт, эм олгох үйл ажиллагааг зохицуулах журам батлах тухай” А/407 дугаар тушаалд дараах нэмэлт, өөрчлөлт оруулсугай.

1.1 Тушаалын нэгдүгээр хавсралтын 2.5 дахь хэсгийн “...сар бүр олгоно.” гэсний дараа “Уналт, таталт өвчний үед хэрэглэх эмийн нөөцийг харгалзан нийтийн үйлчилгээтэй эмийн сангаас олгож болно.” гэж нэмсүгэй.

1.2 Тушаалын нэгдүгээр хавсралтын 3.1.1 дэх хэсгийн “..... Монгол Улсад бүртгэлтэй, олон улсын эмнэлзүйн удирдамжид үндэслэн.....” гэснийг “Монгол Улсын болон олон улсын эмнэлзүйн удирдамжид зөвлөсөн эмчилгээний практикт хэрэглэгдэж буй эмийн мэдээлэлд үндэслэн...” гэж, тушаалын хоёрдугаар хавсралтаар батлагдсан “Төрөөс эмийн зардлыг нь хариуцан амбулаториор эмчлэх өвчний жагсаалт” –ын 2 дугаарт заагдсан Уналт таталтын (эпилепси), 6 дугаарт заагдсан Чихрийн шижин өвчний шалгуурын хэсэгт “хүүхэд” гэснийг, “бүх тохиолдолд” гэж, 18 дугаарт заагдсан “Хорт хавдрын /бүх төрлийн/ дөрөвдүгээр үе шат” гэснийг “Бүх төрлийн хорт хавдрын дараах бай болон хөнгөвчлөх эмчилгээ” гэж тус тус өөрчилсүгэй.

2. Тушаалын дагуу холбогдох зохицуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар (С.Энхболд), Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар (П.Алтанцэцэг), бүх шатны төрийн өмчит эрүүл мэндийн байгууллага, эмийн сангийн дарга, захирал нарт үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (С.Төгсдэлгэр)-т үүрэг болгосугай.

САЙД  Т.МӨНХСАЙХАН